

Б.Анхбаяр¹✉, Ж.Баярсайхан², Г.Анхсанаа³¹ШУА-ийн Археологийн хүрээлэн, Монгол улс, Улаанбаатар-13330, Энхтайвны өргөн чөлөө, ШУА-ийн хүрээлэнгүүдийн нэгдсэн I байр²Макс Планкын Биохимийн салбар хүрээлэн, Ханс-Ноеллийн гудамж, 10, 07745, Иена, ХБНГУ³Соёлын Өвийн Үндэсний Төв, Монгол улс, Улаанбаатар, Хан-Уул дүүрэг 21-р хороо, Буянт Ухаа 2 хороолол

Хөвсгөл аймгийн нутгаас шинээр илрүүлсэн хүн чулууд

Товчлол. 2020 онд Хөвсгөл аймгийн нутгаас иргэдийн санамсаргүй олсон олдворууд хүрэл, төмрийн түрүү үеийн ховор, түүхийн үнэт дурсгал болох нь тодорхой болсон тул тэдгээрийн олдсон газрыг нарийвчлан нягтлан судлах зайлшгүй авран хамгаалах ажлын явцад 3 хүн чулуу, тахилын онгоныг бүртгэн баримтжууллаа. Тэдгээр хүн чулуудын дүрслэл, дүр байдал, бүрэлдэхүүн нь Эртний Түрэгийн хаант улсын үед холбогдож байна. Зарим хүн чулуунд чулуун хашлага, шороон хэрэм, зэл чулуу бүхий тахилын онгонтой тул өндөр язгууртай хүнд зориулсан дурсгал болохыг илтгэж байлаа. Дээрх хэрэглэгдэхүүн Монгол орны умар нутаг дахь дундад эртний түүх соёлын асуудлуудыг тодруулахад нэмэр болох нь дамжиггүй.


Түлхүүр үг: Хөвсгөл аймаг, хүн чулуу, түрэг

B.Ankhubayar¹✉, J.Bayarsaikhan², G.Ankhsanaa³¹Institute of Archaeology, Mongolian Academy of Sciences, Building-1, Peace avenue, Ulaanbaatar-13330, Mongolia²Max Planck Institute for Geoanthropology in Germany, Max Planck Institute for Biogeochemistry, Hans-Knoell-Str. 10, 07745 Jena, Germany³National Center of Cultural Heritage, Khan-Uul district 21th khoroo, Buyant-Ukhaa 2 block, National Center of Cultural Heritage

Newly discovered anthropomorphic Stone Statue from territory of Khövsgöl aimag

Summary. In 2020, these 3 anthropomorphic stone stelae and their ritual components were registered and documented during the fieldwork to rescue very rare and valuable historical finds of the Bronze and Early Iron Ages which were randomly found by local people in Khövsgöl aimag. It was able to date these anthropomorphic stones back to the time of the ancient Tureg Khaganate of Inner Asia based on their form, depictions, and compositions. One of them is clearly representing that the monument for the high-ranking person in terms of components such as a stone box, an earthen wall, and a line of standing stones as known as balbal. This pilot study will help to clarify the issues of early medieval history and culture in the northern part of Mongolia.

Keywords: Khövsgöl aimag, stone statues, Tureg Khaganate



Удиртгал

Хөвсгөл аймгийн Түнэл сумын нутгаас эртний хүрэл зэвсгийн үеийн эдлэлүүд олдсоныг хүлээн авах, тухайн эд өлгийн зүйл анх олдсон газарт нь очиж шалгах ажлын хэсгийг Соёлын сайдын тушаалаар байгуулж, 2021 оны 5 сарын 24-30-ны хооронд томилон ажиллуулсан юм. Уг ажлын хүрээнд бидний очиж ажилласан Түнэл сумын болон буцах зам дагуу Их уул, Рашаант сумын иргэдийн өгсөн мэдээллийн шалгах явцад 3 хүн чулуу, тахилын онгон бүхий дурсгалыг бүртгэн баримтжуулав [Баярсайхан нар. 2021]. Тэдгээрийн хоёр нь манай улсын түүх соёлын өвд бүртгэгдээгүй шинэ дурсгал байлаа. Тиймээс дурсгалуудыг нийлүүлэн баримтжуулаад судалгааны эргэлтэд оруулж байна.

Талын толгойн хүн чулуу

Хөвсгөл аймгийн Түнэл сумын төвөөс урагш 17 км зайд Хөндий хэмээх уужим хөндийн төгсгөл, баруун урдаас зүүн хойш сунаж тогтсон модтой багахан нуруун ард, Хар усны голын зүүн эрэгт нэгэн хүн чулуун хөшөө байна. Хүн чулуун хөшөөний урд зүгт харагдах хэдэн толгойг Талын таван толгой гэх бөгөөд Сул толгой, Ноён толгой, Дунд толгой, Халзан толгой, Үзүүр толгой хэмээнэ. Уг хөшөөг 2021 оны хавар Түнэл сумын иргэн Ж.Самбалхүндэв мэдээлж, улмаар сумын түүх - соёлын дурсгалын тоонд бүртгэжээ. Газар зүйн байршил нь $49^{\circ}48'7.22''$ $100^{\circ}37'38.72''$ солбицолд оршино. Хөшөөг бор саарал өнгийн боржин чулууг засаж үйлдээд нүүрээр нь зүүн урд зүгт хандуулан босгожээ. Одоо байгаа хэмжээ нь 92 см өндөр, 41 см өргөн, 30 см зузаан, зүүн хойш 30 хэм налж хазайжээ. Хөшөөний байдал, суурийг ажиглахад анхны байрлалаасаа

хөдлөөгүй боллоотой. Дүрслэлийн хувьд, хүний толгойн оройг засаж мөлийлгөөд толгой мөрийг зааглаж тодруулан цохисон ором мэдэгдэнэ. Нүүр болон бусад эрхтэн хувцас хунар мэдэгдэхгүй, ихэд элэгджээ (Зураг 1).

Үертийн тагийн хүн чулуу


Хөвсгөл аймгийн төв Мөрөн хотоос зүүн хойш 20 км зайд, Түнэл сумын төвөөс баруун урагш 22 км зайд Үертийн таг хэмээх модтой өндөр уулын зүүн хойд шувтарга, Хүн чулууны таг хэмээх газарт нэгэн хүн чулуу бий. Газар зүйн байршил нь $49.43'00.07''$ $100.24'58.00''$ солбицолд далайн түвшнээс дээш 1650 м өндөрт байрлана. Хүн чулуунаас өмнө зүгт 2 км зайд Ачмаг нуур хэмээх үзэсгэлэнтэй багавтар нуур харагдана. Хар сааралдуу өнгийн боржин чулууг сонгон авчирч хүний нүүрийг зүүн өмнө зүгт харуулан босгоод дайрган чулуугаар чигжсэн байна. Хүн чулууны дээд хэсэг нарийн шувтан, сууриараа өргөн. Уг хөшөө 97 см өндөр, сууриараа 46 см, дээгүүрээ 18 см өргөн, 27 см зузаан. Уг хүн чулуунд зөвхөн хүний нүүр, малгайг дүрсэлсэн байна. Хүний нүүрийг урт тахир хөмсөгтэй, бүлтгэр том нүдтэй, урт унжуу хамартай, богино нарийвтар амтай дүрсэлжээ. Харин толгой дээр намхан шовгор оройтой, чихээ дарж унжуулсан малгай өмсүүлсэн байна (Зураг 2). Уг дурсгалыг 2015 онд тоймлон тодорхойлоод Монгол улсын Соёлын өвийн бүртгэл мэдээллийн санд бүртгэжээ.

Тохойн талын хүн чулуу, тахилын онгон

Хөвсгөл аймгийн Рашаант сумын Энх тал багийн нутаг Тохойн талд шороон хэрэм, чулуун хашлага, хүн чулуу, зэл чулуу бүхий тахилын



Зураг 1.Талын толгойн хүн чулуу



Гар зураг 1.Талын толгойн хүн чулууны зураглал

онгон бий. Уг хүн чулуу хажуугаараа унан булагдаад зүүн мөр гарны зарим хэсэг хөрснөөс ил гарч байжээ. Тэр нь нутгийнханд махчин араатны хөл сарвуу мэт харагддаг тул “Бар чулуу” хэмээн нэршил авч зарим малчид шүтээний газар хэмээн эрхэмлэж ирсэн байна. Уг дурсгалыг 2021 оны хавар тус багийн малчин П.Мөнхтүвшиний мэдээллээр Рашаант сумын Соёлын төвийн ажилтнууд очиж бүртгээд босгосон байна.

Тохойн тал бол сумын төвөөс өмнө зүгт холгүй орших багавтар уулсаар хүрээлэгдсэн тэнэгэр сайхан хөндий ажээ. Хөндийн баруун урдаас Тохойн гол хэмээх жижиг цэнгэг гол тахиралдан умар зүг рүү урсах бөгөөд голын зүүн эрэгт хүн чулуут тахилын онгоныг байгуулжээ. Хүн чулууны зүүн талаар Залаагийн ам, зүүн хойно Яргайт уул,


Сүүжийн булан, баруун хойно Баянзүрх уул, урд зүгт Мэлхийт хөтөл бараална. Дурсгалын байршил умард өргөргийн $49^{\circ}01'49.11''$ дорнод уртрагийн $101^{\circ}51'68.8''$ солбицолд, далайн түвшнээс дээш 1476 м өндөрт оршино.

Тохойн голын зүүн эргээс 30 м зайд тэгш талбайд сонгон үүдийг зүүн урагш хандуулсан дөрвөлжин зохиомжтой шуудуу ухаад гарсан шороогоор гадуур нь тойруулан хэрэм дэлдэн бүтээжээ. Одоо мэдэгдэж буй шуудууны дундаж өргөн 3 м, гүн 5 см орчим. Хэрмийн дундаж өргөн 4 м, үүдний өргөн 4 м. 15 см орчим өндөр бол зүүн, баруун тал тус бүр 18 м урт, өмнө тал 19 м, хойд тал 17 м урт (зураг 3).

Тахилын хашлага: Шороон хэрмийн төвд зүүн тийш чиглүүлэн суулгасан дөрвөн тал хашлага



Гэрэл зураг 2. Үертийн тагийн хүн чулуу



Гар зураг 2. Үертийн тагийн хүн чулуу



Фотограмметр зураг

чулууны нэг нь хуучин сууриндаа үлдсэн бол үлдсэн 3 тал дотогшоо унаад дарагджээ. Одоо байрандаа үлдсэн хашлага чулуу 144 см урт, 70 см өндөр, 13 см өргөн аж.

Хүн чулуу: Тахилын хашлагаас зүүн урагш 20 см зайд цайвар бор өнгийн боржин чулуугаар үйлдэн зүүн урагш хандуулан босгосон толгойгүй хүн чулуу бий. Хүн чулуу анх босгосон сууриндаа хажуудан унаж олон жил болсон тул харьцангуй сайн хадгалагдсан байна. Харин босгохдоо хуучин байрлалаас багахан зөрүүлжээ. Хүн чулууг нутгийн малчид “бар чулуу” хэмээн нэрлээд цөөн айл удмын шүтээн болгон тахидаг гэнэ. Хүн чулуу 95 см өндөр, 58-60 см өргөн, 24 см зузаан хэмжээтэй. Дүрслэлийн хувьд, баруун гарыг тохойгоор нугалан цээжин тус газраа

авчирч цомоо хундага барьсан, зүүн гараараа бүсний орчимд чинжаал хутга барьсан. Өргөн суга, нарийн ханцуйтай, босоо энгэртэй дэлгэмэл захтай урт дээл өмсүүлж, олон товгор чимэглэлтэй суран бүстэй, уужим зулагтай урт түрийтэй гутал өмсүүлэн завилж суугаа байдлаар дүрсэлсэн толгойг эрт цагт эвдэж сүйтгэсэн байна.


Зэл чулуу: Хүн чулууны өмнөөс 4 м зайд болон 7 м зайд хоёр босоо чулуунаас эхлэн 540 м урт үргэлжилсэн 61 ширхэг зэл чулуутай. Эхний хэдэн чулуу босоо бусад нь бүгд унажээ. Чулууны дундаж хэмжээ 60 см өндөр .

Хэлэлцүүлэг

Манай улсын нутагт хийсэн археологийн судалгаагаар түрэг угсааны нүүдэлчдийн




Гэрэл зураг 3. Тохойн талын хүн чулуу, тахилын онгон



0 50 cm

Гар зураг 3. Тохойн талын хүн чулуу



Фотограмметр зураг



Гэрэл зураг 4. Тохойн талын хүн чулуу, тахилын онгоны зураглал/зүүн урд талаас/

түүхэнд холбогдох 785 хүн чулуу бүртгэгдсэн [Амартүвшин нар. 2016:38] байхаас Хөвсгөл аймгийн нутагт Тариатын давааны хүн чулуу, Цагаан эргийн Далхын хүн чулуу, Овооны эрэг модны хүн чулуу зэрэг хүн чулуу зэрэг дурсгал судалгааны эргэлтэд оржээ. Харин бидний үзсэн дээрх хүн чулууд, тахилын онгоны хийц, дүрслэл

дүр байдал нь судлаачдын эртний түрэгийн үед холбогдуулан үздэг дурсгалтай адил байна. Хүн чулууг баатар дайчин эрс, өндөр дээд язгууртанд зориулан үйлддэг хэмээн үздэг бөгөөд хүн чулууны байр зүй, өмсгөл, дүр байдал зэргээс харахад овог аймаг, угсаа гарал, нийгмийн гарал, бүс нутгийн зэрэг олон ялгаа мэдэгддэг байна.

Энэ удаад илрүүлсэн хүн чулуудын дүрслэл, байр зүй, бүрэлдэхүүний хувьд өөр хоорондоо ялгаатай аж. Судлаач Д.Баярын ангиллаар Үертийн тагийн хүн чулуу заримдаг дүрслэлтэй, Талын толгойн хүн чулуу тойм дүрслэлтэй, Тохойн талын хүн чулуу бүрэн дүрслэлтэй байна. Харин байр зүйн хувьд уулын нуга хөндий, уулын орой, тэгш талархаг хөндийд тус тус байрлуулжээ. Үертийн тагийн хүн чулууг уулын оройд зүүн урд зүгт хандуулан байрлуулсан нь алсын бараа, байгалийн сайхныг харуулахаар бодолцсоныг шууд илтгэнэ. Манай улсын нутгаас олдсон түрэгийн үеийн хүн чулуудын дунд уулын оройд буй Жамбалдорж [Эрдэнэбат нар. 2008:150], Шивээт уул [Батсайхан 2008:110], Тарнийн гол [Наваан нар. 1992:34], Цагаан чулуутын увшхай [Мэнэс 1983:24], [Баяр 1992:34] зэрэг газраас олдож байжээ. Түрэгийн үеийн цөөн хүн чулууг уулын оройд хүн чулуу босгосон байгаа явдал нь өвөрмөц заншил бөгөөд тэдгээрийн ихэнх нь байгалийн хад цохионы хөмөг, хүний гараар үйлдсэн чулуун байгууламж дотроос олддог байна. Харин Үертийн тагийн хүн чулуу дээрхээс ялгаатай нь нөмөр цохион доор бус ганцаараа оршиж буй. Ямар боловч баатар дайчин эр, язгууртанд бус байгаль дэлхийтэй ойр харьцдаг, өвөг дээдэс, эсвэл тэнгэр шүтээнтэйгээ харилцагчдад зориулсан чулуун хөргийг уулын оройд босгодог юм биш биз гэсэн таамаг дэвшүүлж байна.

Тохойн талын хүн чулуутай тахилын онгоны цогцолборыг голын эрэг дээр тэгш сайхан талд сонгон залуу боржин чулууг засаж дээл хувцас, бүс, гутал зэргийг тун уран чадмаг урласны зэрэгцээ завилан суугаа төрхийг тодосгоод өндөр том тахилгын хашлага, дөрвөлжин хэлбэртэй шороон хэрэм, хагас км урт үргэлжилсэн зэл чулуу зэргийг байгуулсан нь яах аргаггүй өндөр язгууртанд зориулсан “тахил шүтээний цогцолбор” [Баяр 1997: 69] болохыг илтгэнэ.

Хөвсгөлаймгийн нутагт ажилласан энэ удаагийн гүймэг судалгааны үр дүнгээс харахад Түрэгийн үеийн хүн чулуу, тахилын онгон нэмэгдэж олдох хандлагатай байгаа тул цаашид энэ бүс нутагт хүн чулуу тахилын онгоны судалгааг эрчимжүүлж Монгол орны умард бүсийн хүн чулууны тархалтыг тэлэх, дүр дүрслэлийн онцлогийг тодруулах зэрэг түүх соёлын асуудлуудыг шинэ баримт, шинэ мэдлэгээр баяжуулах боломжтой байна.

Талархал

Хүн чулуу, тахилын онгоны тухай мэдээлж газарчилсан Хөвсгөл аймгийн Соёлын газрын мэргэжилтэн Х.Баасансүрэн, Түнэл сумын засаг дарга Д.Цогбаяр, орлогч дарга Ж.Самбаллхүндэв, Соёлын төвийн эрхлэгч Д.Түмэнбаяр, түүхийн багш М.Ганболд, Рашаант сумын Соёлын төвийн эрхлэгч Л.Баярцэнгэл болон гар зураг, газрын зураг үйлдсэн СӨҮТ-ийн ажилтан Б.Амгаланбат, С.Баасандорж нартаа талархал илэрхийлье.

Ном зүй

Баярсайхан нар. 2021 – Баярсайхан Ж., Анхсанаа Г., Анхбаяр Б. Хөвсгөл аймгийн Түнэл сумын нутгаас санамсаргүй илрүүлсэн эртний олдворуудыг Соёлын яаманд шилжүүлэн авчрах, олдсон газрыг нягтлан шалгах судалгааны багийн тайлан. УБ, 2021 Археологийн хүрээлэнгийн Гар бичмэлийн сан хөмрөг.

Батсайхан 2008 – Батсайхан З. Шивээт уулын том чулуун байгууламж. – *Mongolian journal of Anthropology, Archaeology, Ethnology*. Vol 4, №1 UB., 2008.

Эрдэнэбат нар. 2008 - Эрдэнэбат У., Батбаяр Т. Жамбалдоржийн тухай тэмдэглэл. – *Mongolian journal of Anthropology, Archaeology end Ethnology*. УБ, 2008 Vol.4, №1(312)

Наваан нар. 1987 - Наваан Д., Лхагвасүрэн Х. Өвөрхангай Бүрд сумын нутаг Тарнийн гол 1987 он.

Мэнэс 1983 - Мэнэс Г. 1983 оны археологийн хээрийн шинжилгээний тайлан. ТХГБФ.

Баяр 1992 – Баяр Д. Өвөрхангай аймгийн нутагт буй түрэгийн үеийн хүн хөшөөний тухай. – Археологийн судлал. Томус 13. УБ, 1992.

Баяр 1997 – Баяр Д. Төв Монголын нутаг дахь түрэгийн хүн чулуу. УБ, 1997.

Амартүвшин нар. 2016 – Эрхэлсэн Амартүвшин Ч., Бадма-Оюу Б. Монголын хүн чулуу. – Монголын археологийн өв -V. УБ, 2016.